



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

### Нийслэлийн Бизнесийн инновац хөгжлийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.ХБНГУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны (GIZ) нийгэмлэгийн хандиваар өгсөн нийт 29,090,909.09 (хорин есөн сая ерэн мянга есөн зуун есөн төгрөг есөн мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар (Б.Билгүүн)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газар (Б.Билгүүн)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500078

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2024 оны 02 дугаар сарын 15 -ний өдрийн  
А/23 дугаар тушаалын хавсралт



### Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Бизнес инновац хөгжлийн газар

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр	
								Нэгж үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Дэлгэц	PS91177001	4к дотор	18/12/2023	Сайн	ш	9	2,536,363.64	22,827,272.73	ХБНГУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны (GIZ) нийгэмлэг	Хандив
2	Дэлгэцийн хүлээн авагч	PS91177001	Оролт 8, гаралт 16	18/12/2023	Сайн	ш	1	2,354,545.45	2,354,545.45		
3	Дэлгэцийн программ	PS91177001	-	18/12/2023	Сайн	ш	9	286,363.64	2,577,272.73		
4	HDMI холбогч кабел	PS91177001	15м урт	18/12/2023	Сайн	м	15	145,454.55	1,309,090.91		
5	HDMI холбогч кабел	PS91177001	3м урт	18/12/2023	Сайн	м	3	22,727.27	22,727.27		
Бүртгэх хөрөнгийн дүн									29,090,909.09		